

МЭДЭЭЛЭЛ

Дэрэвгэр жиргэрүү ургамлын хууль бус ашиглалт,
шийдвэрлэгдсэн байдал

Халтарын Оюунбилэг¹, Оюунбилэгийн Мөнхзул^{2*}, Сайннэмэхийн
Сүмжидмаа³, Батлайн Оюунцэцэг²

¹Байгаль Орчин Уур Амьсгалын Өөрчлөлтийн Яам, Хяналт, үнэлгээ, аудитын газар, 17100, Монгол

²Монгол Улсын Их Сургууль, Шинжлэх Ухааны Сургууль, Байгалийн Ухааны Сургууль,
Биологийн тэнхим, 14200, Монгол

³Монголын Бэлчээр Ашиглагчдын Нэгдсэн Холбоо, 13381, Монгол

*И-мэйл: munkhzulbot@gmail.com, <https://orcid.org/0000-0002-4399-416X>

<https://doi.org/10.5564/mjb.v6i32.3824>

Хүлээн авсан: 2024.06.06

Хянасан: 2024.09.25

Хэвлэлтэнд: 2024.10.08

Хураангуй Монгол оронд 1100 гаруй зүйлийн эмийн ургамал байдгийн 30 орчим хувь нь түгээмэл хэрэглэгддэг. Үүний нэг нь Дэрэвгэр жиргэрүү (*Saposchnikovia divaricata* (Turcz.) Schischk.) бөгөөд уг ургамал нь тус улсын ховор, эмзэг ургамлын жагсаалтад ордог. Гэвч сүүлийн жилүүдэд хэт их хэмжээгээр түүж бэлтгэх, хууль бусаар худалдаалах, экспортлох болсоноос нөөцийн хэмжээ багасч байна. Тухайн ургамлын биологийн нөөц Монгол орны хэмжээнд тодорхойгүй боловч тодорхой бүс нутгуудын хэмжээнд хийгдсэн судалгааны ажлуудад үндэслэн хуулийн хүрээнд түүж бэлтгэх хэмжээг жил бүр улсаас тогтоодог. Гэвч тухайн ургамлыг улсаас тогтоосон хэмжээнд болон хууль бусаар хир хэмжээнд түүж бэлтгэж байгаа талаар мэдээ баримт хомс байна. Иймд бид хуулийн хүрээнд шийдвэрлэгдсэн хэргүүдийг Монгол улсын шүүхийн цахим сан, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны цахим сангуудаас шүүж, тоон мэдээлэл цуглуулж, хэрхэн зохицуулагдаж байгаа талаар дүн шинжилгээ хийхийг зорьлоо. Бид Монгол улсын Шүүхийн шийдвэрийн цахим сангаас Дэрэвгэр жиргэрүүтэй холбоотой 191 хэрэг бүртгэгдсэнийг илрүүлсэн ба үүний 122 нь Эрүүгийн анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн байна. Үүнд: зөвшөөрөлгүйгээр түүж бэлтгэсэн 56, хадгалсан 35, тээвэрлэсэн 49, худалдан авсан 31, хилээр хууль бусаар нэвтрүүлсэн 36 хэрэг байна. Энд нийт 22 тонн Дэрэвгэр жиргэрүү ургамлын үндсийг хууль бусаар бэлтгэж, байгаль орчинд 2.3 тэрбум төгрөгийн хохирол учруулсан нь тогтоогдсон. Мөн Байгаль орчны статистикийн мэдээллийн санд ЦЕГ-т байгаль орчинд 0.8 тэрбум төгрөг (5.4 тонн үндэс), МХЕГ-т 0.3 тэрбум төгрөг (2.5 тонн үндэс)-ийн хохирол байгаль орчинд учруулжээ.

Түлхүүр үг: Дэрэвгэр жиргэрүү, хууль бус ашиглалт, гэмт хэрэг

Эшлэл авахдаа: Оюунбилэг Х., Мөнхзул О*, Сүмжидмаа С., Оюунцэцэг Б. 2024. Дэрэвгэр жиргэрүү ургамлын хууль бус ашиглалт, шийдвэрлэгдсэн байдал. *Монголын ботаникийн сэтгүүл*, 06 (32): 114-122.


Удиртгал

Дэлхий дээр нийт 77 мянган зүйлийн эмийн ургамал (нийт ургамлын 18.2%) байгаагаас 3000 гаруй зүйл нь олон улсад түгээмэл худалдаалагдаж байна

(Rajeswara Rao et al., 2014). Дэлхийн ургамлын гаралтай бүтээгдэхүүний зах зээл 83 тэрбум ам доллароор хэмжигдэх (Robinson et al., 2011) бөгөөд энэ тоо өссөөр 2050 онд 5 их наяд ам долларт хүрэхээр байна (Parvin et al., 2023). Монгол оронд 1100 гаруй зүйлийн эмийн ургамал (Ургамал, 2017) байгаагаас уламжлалт анагаах ухаанд 300 гаруй зүйл нь түгээмэл ашиглагдаж байна (Эм зүйн салбар дахь генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийн хэрэглээ, 2018). Судлаачид Чихэр өвс, Зээргэнэ, Цөлийн аргамжин цэцэг, Эгэл бавран, Дэрэвгэр жиргэрүү, Монгол хунчир зэрэг 102 зүйлийн ургамал гадаадын зах зээлд хууль бусаар худалдаалагдах магадлалтайг тогтоожээ (Амарзаяа нар., 2018).

Дэрэвгэр жиргэрүү ургамал нь Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоол ёсоор “Ховор” (Засгийн газрын тогтоол, 1995; Байгалийн ургамлын тухай хууль, 1995), Дэлхийн байгаль хамгаалах холбооны бүс нутгийн үнэлгээгээр Эмзэг (VU) B2ab(ii, iii) (Ургамал нар., 2019) ангилалд багтдаг. Уг ургамлын үндсийг (Ligaa et al., 2009) эмийн зориулалтаар ашигладаг. Сүүлийн жилүүдэд хэт их хэмжээгээр түүж бэлтгэх, хууль бусаар худалдаалах (Ургамал нар., 2019), экспортлох (Суран нар., 2022) болсон тул цаашид ховордож устахаас урьдчилан сэргийлэх, нөөцийг хамгаалах зорилгоор Байгаль орчин аялал жуулчлалын сайдын тушаал (2018a)-аар 5 жилийн (2018-2023) хугацаанд түүж бэлтгэхийг түр хориглосон.

Байгалийн Дэрэвгэр жиргэрүү ургамлын биологийн нөөц БНХАУ-д 2000-аад оны эхээр 20 мянган тонн байснаа 2012 онд 1300 тонн болж, 15 дахин буурсан (Ding, 2012) бол тус ургамлын үндэсний эрэлт хэрэгцээ 2001 онд 1300-1500 тонн байснаа 2014 онд 7000-8000 тонн болж, 5 дахин өссөн. Улмаар байгалийн Дэрэвгэр жиргэрүүгийн үндэсний үнэ өссөөр, 2019 онд 300 юань/кг (115700 төгрөг/кг) хүрсэн бол таримал үндэсний үнэд өөрчлөлт бага байна (Lyu et al., 2022) (Зураг 7).



Зураг 7. БНХАУ-ын байгалийн болон таримал Дэрэвгэр жиргэрүү ургамлын үндэсний үнэ [Эх үүсвэр: (Lyu et al., 2022)]

Байгаль орчин аялал жуулчлалын сайдын тушаалаар (2017, 2018b, 2019, 2020a, 2021, 2022a, 2023) 2016-2017 онд Дэрэвгэр жиргэрүү ургамлын 235 тонн үндсийг үйлдвэрлэлийн зориулалтаар, 2017-2023 оны тушаалаар 2.2 тонн үрийг тарималжуулах зориулалтаар түүж бэлтгэх зөвшөөрөл олгожээ (Хүснэгт 6).

Хүснэгт 6. Жилд бэлтгэх дээд хэмжээ болон экологи-эдийн засгийн үнэлгээ (Байгаль орчин аялал жуулчлалын сайдын тушаал, 2020b, 2022b)

Он	Бэлтгэх түүхий эд	Бэлтгэх хэмжээ, кг	Экологи эдийн засгийн үнэлгээ	
			Нойтон	Хуурай
2016	Үндэс	90,000	-	50,000
2017	Үндэс	145,000	-	50,000
	Үр	100	-	50,000
2018	Үр	200	-	50,000
2019	Үр	300	-	50,000
2020	Үр	300	112,900	217,100
2021	Үр	150	112,900	217,100
2022	Үр	400	112,900	217,100
2023	Үр	800	112,900	217,100

Судалгааны материал, аргазүй

Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим сан (www.shuukh.mn)-аас 2016.01.01-2024.05.01-ны өдрөөр зааглан, ‘дэрэвгэр жиргэрүү’ гэсэн түлхүүр үг ашиглан хайлт хийхэд 191 илэрцтэй байв. Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс Дэрэвгэр жиргэрүү ургамлыг зөвшөөрөлгүй түүж бэлтгэсэн, хадгалсан, тээвэрлэсэн, худалдан авсан, хууль бусаар улсын хилээр нэвтрүүлсэн гэмт хэрэг үйлдэж, гэм буруутайд тооцсон 122 сонгомол шийдвэрт боловсруулалт хийлээ.

Монгол улсын Байгаль орчин, аялал жуулчлалын яамны цахим сан (www.eic.mn)-ын Байгаль орчны статистикийн мэдээлэл БОХ4.4а маягт, Хууль бусаар бэлтгэсэн, ашигласан амьтан, ургамлын жилийн мэдээ, ЦЕГ (Байгаль орчин аялал жуулчлалын яам, 2024b) 2019-2023 онд 23, БОХ4.4б маягт, Хууль бусаар бэлтгэсэн, ашигласан амьтан, ургамлын жилийн мэдээний маягт, МХЕГ (Байгаль орчин аялал жуулчлалын яам, 2024a) 2019-2023 онд 5 өгөгдөл бүртгэгдсэнд боловсруулалт хийв.

Судалгааны үр дүн, хэлэлцүүлэг

Шүүхийн шийдвэрийн цахим сан

Монгол улсын Шүүхийн шийдвэрийн цахим санд (2016.01.01-2024.05.01) Дэрэвгэр жиргэрүү ургамалтай холбоотой 191 шийдвэр байгаагийн 63.8%-ийг Эрүүгийн анхан шатны шүүхээр шийдэгдсэн хэрэг эзэлж байна (Хүснэгт 7). Түүж бэлтгэхийг түр хугацаагаар хориглосон 2018-2023 онд шийдвэрлэгдсэн хэрэг 79.5%-ийг бүрдүүлж байна.

Хүснэгт 7. Дэрэвгэр жиргэрүү ургамалтай холбоотой шийдвэрүүдийн шүүхээр шийдвэрлэгдсэн байдал

Шүүх	Шүүхийн шийдвэрийн шат	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	Нийт
		Иргэний хэргийн шүүх	Анхан шат	1	-	-	1	1	-	-	
	Давж заалдах шат	1	2	-	-	-	-	-	-	-	3
	Хяналтын шат	-	1	-	-	-	-	-	-	-	1
Эрүүгийн хэргийн шүүх	Анхан шат	4	19	23	20	21	18	9	6	2	122
	Давж заалдах шат	1	-	10	2	9	8	9	1	2	42
	Хяналтын шат	1	-	3	1	1	1	1	2	-	10
Захиргааны хэргийн шүүх	Анхан шат	-	-	2	1	3	-	-	-	-	6
	Давж заалдах шат	-	-	1	-	2	-	-	-	-	3
	Хяналтын шат	-	-	-	-	-	1	-	-	-	1

Зорчлийн байдал: Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн 122 хэргийг задалвал: 41.2%-ийг зөвшөөрөлгүй түүж бэлтгэсэн, 25.7%-ийг хадгалсан, 36%-ийг тээвэрлэсэн, 22.8%-ийг худалдан авсан, 26.5%-ийг хилээр нэвтрүүлэхийг завдсан хэргүүд бүрдүүлж байна. Нийт хэргийн 70%-ийг Дорнод, Сэлэнгэ, Өмнөговь аймагт бүртгэгдсэн хэргүүд эзэлж байна (Хүснэгт 8).

Хүснэгт 8. Дэрэвгэр жиргэрүү ургамалтай холбоотой хэргийн тоон мэдээ

Аймаг	Нийт	Түүж, бэлтгэсэн	Хадгалсан	Тээвэрлэсэн	Худалдан авсан	Монгол Улсын хилээр хууль бусаар нэвтрүүлсэн
Булган	3	3	2	1	-	-
Дархан-Уул	5	4	2	3	1	2
Дорноговь	11	1	3	2	1	7
Дорнод	53	28	19	22	15	8
Орхон	1	-	1	1	1	-
Өмнөговь	15	1	3	5	3	11
Сүхбаатар	5	-	-	3	3	5
Сэлэнгэ	18	15	1	5	2	-
Улаанбаатар	11	4	4	7	5	3
Нийт	122	56	35	49	31	36

Шийдвэрлэсэн байдал: Нийт хэргийн 69.7%-ийг торгох ялаар шийтгүүлсэн хэрэг, 57.4%-ийг тэнсэх ялаар шийтгүүлсэн, 10.7%-ийг хорих ялаар шийтгүүлсэн хэрэг эзэлж байна (Хүснэгт 9).

Хүснэгт 9. Эрүүгийн анхан шатны шүүхээр шийдэгдсэн хэргийн ялын ангилал

Ургамлын хэмжээ, кг	Нийт тоо	Хэргэ сэхгүй	Торгох ял (сая төгрөг)		Тэнсэх ял (жил)			Зорчих эрх хязгаарлах (жил)		Хорих ял (жил)		
			0-10	10 дээш	1	2	3-5	1	2-4	1	2	6
1-10	28	1	19	2	16	4	-	-	-	2	-	-
11-20	21	-	16	-	10	3	1	2	-	2	-	-
20-50	17	-	11	2	5	5	-	1	-	-	1	-

50-100	14	-	4	6	5	3	-	-	-	1	1	-
100-200	10	-	2	4	3	3	-	-	-		2	-
200-300	10	-	3	5	-	3	1	-	1	-	-	-
300-500	10	-	2	4	1	2	-	1		1	1	1
500-1000	4	-	-	1	2	1	-	-	-	-	-	-
1000-2000	5	-	1	1	1	1	-	1	1	-	-	-
2000-5000	2	-	-	1	-	-	-	-	-	-	1	-
5000-10000	1	-	1	-	-	-	-	-	-	-	-	-
	122	1	59	26	43	25	2	5	3	6	6	1

Торгуулийн хэмжээ: Нийт хэрэгт торгох ял оногдуулсан 85 хэрэг байгаа нь байгаль орчинд 2,312.3 сая төгрөгийн хохирол учруулсан байна. Бага хэмжээний хохирол буюу 10 хүртэлх сая төгрөгийн торгууль бүхий 59 хэрэг нь 145.2 сая төгрөгийн хохирол учруулсан байхад үлэмж болон их хэмжээний хохирол буюу 10-аас дээш сая төгрөгийн торгууль бүхий 26 хэрэг нь 2,167.1 сая төгрөгийн хохирол учруулсан байна (Хүснэгт 10).

Хүснэгт 10. Хохирлын хэмжээ, мөнгөн дүнгээр

Аймаг	Хохирлын ангилал	Хэргийн тоо	Ургамлын хэмжээ, кг	Торгууль, төгрөг
Булган	10 сая хүртэл	2	36.5	11,154,100
	10 саяас дээш	1	43.2	14,631,200
Дархан-Уул	10 сая хүртэл	2	24.1	6,025,000
	10 саяас дээш	2	155.7	38,626,250
Дорноговь	10 сая хүртэл	8	160.1	9,690,000
Дорнод	10 сая хүртэл	26	9857.2	78,375,522
	10 саяас дээш	10	5292.8	1,066,486,485
Орхон	10 саяас дээш	1	228	80,900,000
Өмнөговь	10 сая хүртэл	8	3111.2	14,700,000
	10 саяас дээш	1	205.9	51,475,000
Сүхбаатар	10 сая хүртэл	3	34.9	2,745,000
	10 саяас дээш	2	488.5	78,025,000
Сэлэнгэ	10 сая хүртэл	8	209.2	15,345,300
	10 саяас дээш	4	372.5	116,656,825
Улаанбаатар	10 сая хүртэл	2	272.9	7,118,075
	10 саяас дээш	5	1532.1	720,324,750
Бусад	10 сая хүртэл	2	45.4	2,270,000
	Нийт	85	22024.9	2,312,278,507

Нийт хэрэг дотор шүүхээс нэхэмжлэх талын нэхэмжилсэн үнийн дүнг 5 дахин нэмэгдүүлэх шийдвэр гаргасан 17 хэрэг, бууруулсан 10 хэрэг, хэвээр үлдээсэн 21, тодорхойгүй 29 хэрэг байна.

- Нэхэмжлэх талын нэхэмжилсэн үнийн дүнг 5 дахин бууруулсан 10 хэргийг шүүхээс “шүүгдэгч тал худалдан авсан, хадгалсан, тээвэрлэсэн бөгөөд байгалиас түүж бэлтгэн байгаль орчинд шууд хохирол үзүүлээгүй” гэж үзсэн байна.

- Эд мөрийн баримтаар хураагдсан Дэрэвгэр жиргэрүү ургамлын үндсийг шүүхийн тогтоол хүчин төгөлдөр болмогц устгахыг даалгасан шүүхийн шийдвэрээр 18 хэргийн нийт 1195_7 кг ургамлыг устгажээ.

Байгаль орчны статистикийн мэдээллийн сан

2019-2023 онд ЦЕГ-т Дэрэвгэр жиргэрүү ургамлын 5.3 тонн үндсийг хууль бусаар бэлтгэж, байгаль орчинд 776.3 сая төгрөгийн хохирол учруулсан 23 хэрэг бүртгэгджээ. МХЕГ (хуучнаар)-т 2.5 тонн үндсийг хууль бусаар бэлтгэж, байгаль орчинд 339.7 сая төгрөгийн хохирол учруулсан 5 хэрэг бүртгэгджээ (Хүснэгт 11).

Хүснэгт 11. Хууль бусаар бэлтгэсэн, ашигласан ургамлын мэдээ (2019-2023)

Аймаг	Хэргийн тоо	Хэмжээ, кг	Ноогдуулсан төлбөр, төгрөг
ЦЕГ			
Дорнод	8	3739.7	589,955,500.0
Сэлэнгэ	5	184.9	25,091,500.0
Дархан	2	115.5	26,701,400.0
Булган	2	236.7	110,898,650.0
Өмнөговь	3	300	12,250,000.0
Орхон	1	79.85	11,400,000.0
Дундговь	2	700	-
Нийт	23	5356.7	776,297,050.0
МХЕГ			
Дорнод	3	2450.1	337,438,050.0
Сэлэнгэ	2	13.6	2,250,000.0
Нийт	5	2463.7	339,688,050.0

Дүгнэлт

- Сүүлийн 9 жилд Дэрэвгэр жиргэрүү ургамалтай холбоотой 191 хэрэг бүртгэгдсэний 64%-ийг зөвшөөрөлгүй түүж бэлтгэсэн, хадгалсан, тээвэрлэсэн, худалдан авсан, хууль бусаар нэвтрүүлсэн гэх сонгомол хэргүүд эзэлж байна.
- Дэрэвгэр жиргэрүү ургамлыг 1 кг, 1000 кг, 9000 кг зөвшөөрөлгүй түүж, бэлтгэсэн, хадгалсан гэх хэргүүдийг яг ижил Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт (Эрүүгийн хууль, 2015) заасны дагуу гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож байна.
- Түүж бэлтгэхийг түр хугацаагаар хориглосон 2018-2023 оны хооронд шийдвэрлэгдсэн хэрэг 79.5% байгаа нь гадаад зах зээлд уг ургамал эрэлттэй, хүмүүсийн дунд хориглосон бараа гэдэг сурталчилгаа, нөлөөллийн ажил дутмаг байсантай холбоотой байж болно.
- Нийт хэргийн 70%-ийг Дорнод, Сэлэнгэ, Өмнөговь зэрэг хилийн боомттой болон уг ургамлын биологийн нөөц ихтэй аймгууд бүрдүүлж байна.
- Хэргийн 70%-ийг торгох ял, 60%-ийг тэнсэх ялаар шийтгүүлсэн хэргүүд эзлэх ба торгох ялын 85%-ийг 0.1-100 кг хүртэлх ургамлын хэргүүд эзэлж байна.

- Торгох ялаар шийтгүүлсэн 85 хэрэг нь байгаль орчинд 2.3 тэрбум төгрөгийн хохирол учруулсан бөгөөд үүний 50%-ийг Дорнод аймагт бүртгэгдсэн 36 хэрэг дангаараа бүрдүүлж байна.
- ЦЕГ-г бүртгэгдсэн 23 хэрэг нь байгаль орчинд 0.8 тэрбум, МХЕГ-т бүртгэгдсэн 5 хэрэг нь байгаль орчинд 0.3 тэрбум төгрөгийн хохирол үзүүлсэн байна. Эдгээрийн 76-99%-ийг Дорнод аймагт бүртгэгдсэн хэргүүд эзэлж байна.
- Хилээр нэвтрүүлэхийг оролдсон хэргүүд нь бүхэлдээ БНХАУ-руу гаргахыг завдсан бөгөөд 54% нь Өмнөговь болон Дорноговь аймгийн хилийн боомтоор нэвтрүүлэхийг оролдсон байна.

Эшилсэн бүтээл

- Ding, L. 2012. Analysis on the trend of production and marketing of Guan Fangfeng. *Modern Chinese Medicine*, 14(3), 1237–1244.
- Ligaa, U., Davaasuren, B., & Ninjil, N. 2009. *Medicinal plants of Mongolia used in Western and Eastern medicine*.
- Lyu, L., Li, X., Zang, E., Yan, Y., Yang, M., Wang, W., Zhang, C., & Li, M. 2022. Specification and grade of Saposchnikoviae Radix (*Saposchnikovia divaricata*). *Chinese Herbal Medicines*, 14(4), 543–553. doi: 10.1016/j.chmed.2021.11.005
- Parvin, S., Reza, A., Das, S., Miah, M. M. U., & Karim, S. 2023. Potential Role and International Trade of Medicinal and Aromatic Plants in the World. *European Journal of Agriculture and Food Sciences*, 5(5), 89–99. doi: 10.24018/ejfood.2023.5.5.701
- Rajeswara Rao, B. ., Syamasundar, K. ., Rajput, D. ., Nagaraju, G., & Adinarayana, G. 2014. Biodiversity, Conservation and Cultivation of Medicinal Plants. *Journal of Pharmacognosy*, 3(2), 59–62. doi: 10.13140/2.1.2927.4247
- Robinson, M. M., & Zhang, X. 2011. The World Medicines Situation. Traditional Medicines: Global Situation, Issues and Challenges. In World Health Organization (Issue 3rd Edition). Geneva.
- Амарзаяа, Д., Чимэдрагчаа, Ч., & Дагвацэрэн, Б. 2018. Монголын уламжлалт анагаах ухаанд өргөн хэрэглэгддэг эмийн түүхий эдийн нөөц, тулгамдсан асуудлууд. Д. Лхагвасүрэн & Н. Сонинхишиг (Eds.), “Биотехнологийн хөгжил ба генетик нөөцийн ашиглалт” онол практикийн бага хурлын эмхэтгэл (pp. 41–47). Улаанбаатар.
- Байгаль орчин аялал жуулчлалын сайдын тушаал. 2017. *Байгалийн ургамал ашиглах дээд хэмжээ тогтоох тухай* (А/169). Улаанбаатар, Монгол.
- Байгаль орчин аялал жуулчлалын сайдын тушаал. 2018а. *Дэрэвгэр жиргээрүү ургамлыг түүж бэлтгэхийг түр хугацаагаар хориглох тухай* (А/43). Улаанбаатар.
- Байгаль орчин аялал жуулчлалын сайдын тушаал. 2018б. *Үйлдвэрлэлийн зориулалтаар 2018 онд түүж бэлтгэх ургамлын дээд хэмжээ* (А/183). Улаанбаатар, Монгол.

- Байгаль орчин аялал жуулчлалын сайдын тушаал. 2019. *Байгалийн ургамал ашиглах дээд хэмжээ тогтоох тухай* (А/302). Улаанбаатар, Монгол.
- Байгаль орчин аялал жуулчлалын сайдын тушаал. 2020а. *Байгалийн ургамал ашиглах дээд хэмжээ тогтоох тухай* (А/483). Улаанбаатар, Монгол.
- Байгаль орчин аялал жуулчлалын сайдын тушаал. 2020b. *Экологи-эдийн засгийн үнэлгээ батлах тухай* (А/677). Улаанбаатар, Монгол.
- Байгаль орчин аялал жуулчлалын сайдын тушаал. 2021. *Байгалийн ургамал ашиглах дээд хэмжээ тогтоох тухай* (А/136). Улаанбаатар, Монгол.
- Байгаль орчин аялал жуулчлалын сайдын тушаал. 2022а. *Байгалийн ургамал түүж бэлтгэх дээд хэмжээ тогтоох* (А/190). Улаанбаатар, Монгол.
- Байгаль орчин аялал жуулчлалын сайдын тушаал. 2022b. *Экологи-эдийн засгийн үнэлгээ батлах тухай* (А/603). Улаанбаатар, Монгол.
- Байгаль орчин аялал жуулчлалын сайдын тушаал. 2023. *Байгалийн ургамал түүж бэлтгэх дээд хэмжээ тогтоох тухай* (А/237). Улаанбаатар, Монгол.
- Байгаль орчин аялал жуулчлалын яам. 2024а. *Хууль бусаар бэлтгэсэн, ашигласан амьтан, ургамлын жилийн мэдээ, МХЕГ*. Retrieved from <https://www.eic.mn/statistic/box44b.php>
- Байгаль орчин аялал жуулчлалын яам. 2024b. *Хууль бусаар бэлтгэсэн, ашигласан амьтан, ургамлын жилийн мэдээ, ЦЕГ*. Retrieved from <https://www.eic.mn/statistic/box44a.php>
- Засгийн газрын тогтоол. 1995. *Жагсаалт батлах тухай (Ховор ургамлын жагсаалт)*. Улаанбаатар. Retrieved from <https://legalinfo.mn/mn/detail?lawId=2696>
- Байгалийн ургамлын тухай хууль, 1995.
- Эрүүгийн хууль, 2015.
- Суран, Д., Оюунцэцэг, Б., Баасанмөнх, Ш., Пүрэвсүрэн, С., Цэгмэд, З., Нямбаяр, Н., & Жамбяанхүү, Н. 2022. *Монгол орны хууль бус ашиглалт, худалдаанд түгээмэл өртөж буй зарим нэн ховор, ховор болон элбэг ургамлууд ба хуулийн хариуцлага*. Улаанбаатар.
- Эм зүйн салбар дахь генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийн хэрэглээ, 2018.
- Ургамал, М. 2017. Ургамлын аймгийн төлөв байдал, өөрчлөгдөл. In Монгол орны байгаль орчин. 3 боть. Монгол орны биологийн олон янз байдал (pp. 1–70). Улаанбаатар.
- Ургамал, М., Оюунцэцэг, Б., Тунгалаг, Р., Гүндэгмаа, В., Оюундарь, Ч., Цэрэндулам, Ц., Мөнх-Эрдэнэ, Т., Солонго, Х., Энхжаргал, Э., Бөхчулуун, Ц., Хэрлэнчимэг, Н., Бүрэнбаатар, Г., Энхтуяа, О., & Жавхлан, С. 2019. *Монгол орны ургамлын улаан данс* (Ц. Цэндээхүү, Ц. Жамсран, С. Гомбобаатар, & Д. Суран (Eds.); Vol. 2). Улаанбаатар.

Illegal harvesting of Sparrow plant (*Saposchnikovia divaricata* (Turcz.) Schischk.) and its policy environment

Oyunbileg Khaltar¹., Munkhzul Oyunbileg^{2*}., Sumjidmaa Sainnemekh³.,
Oyuntsetseg Batlai²

¹ Monitoring, Evaluation and Audit Department, Ministry of Environment and Climate Change, 17100, Mongolia

² Department of Biology, School of Arts and Sciences, National University of Mongolia, 14200, Mongolia

³ National Federation of Pasture User Groups of Herders, 13381, Mongolia

*E-mail: munkhzulbot@gmail.com <https://orcid.org/0000-0002-4399-416X>

Received: 06.06.2024

Revised: 25.09.2024

Accepted: 08.10.2024

Abstract: There are more than 1100 medicinal plant species registered in Mongolian flora, thirty percent of these species are commonly used. The Sparrow plant (*Saposchnikovia divaricata* (Turcz.) Schischk.), which is listed on the rare and vulnerable plant of Mongolia, but it has been in danger of being scarce and destroyed by overharvesting, sales, and exports in recent decades. The biological resource and distribution of the Sparrow plant are not fully studied nationwide, however quota of Sparrow's harvesting is described by state within the legal framework every year based on previous studies in specific regions. Unfortunately, there is still lack of statistical data or information on amount of illegal harvesting and policy regulations related to the Sparrow plant and its trade in Mongolia. Therefore, we searched the information about Sparrow in databases of Mongolian courts' electronic and the Ministry of Environment and Climate Change to gather and analyze. The 191 cases filed in the Electronic Court of Mongolia totally, out of 122 cases were handled by the Court of First Instance. Within these 122 cases, 56 cases of which were unauthorized harvesting, 35 of which were stored, 49 of which were transported, 31 of which were purchased, and 36 of which were illegally smuggled across borders. Consequently, total of 22 tons of Sparrow plants have been illegally prepared and caused 2.3 billion Mongolian tugriks (MNT) of environmental damage. We found that 0.8 billion US dollars (5.4 tons of roots) of environmental damage recorded in General Agency for Police and damage of 0.3 billion US dollars (2.5 tons of roots) of damage recorded in General Agency for Specialized Inspection within Environmental Statistical Database

Keywords: Sparrow plant, *Saposhnikovia divaricata*, conflict, illegal harvesting, regulation.

© The Author(s). 2024 **Open Access** This article is distributed under the terms of the Creative Commons Attribution 4.0 International License (<https://creativecommons.org/licenses/by/4.0/>), which permits unrestricted use, distribution, and reproduction in any medium, provided you give appropriate credit to the original author(s) and the source, provide a link to the Creative Commons license, and indicate if changes were made.